



**Архангай аймгийн Засаг дарга, Засаг даргын
Тамгын газрын 2010 оны үйл ажиллагаанд хяналт
шинжилгээ хийж үнэлгээ өгсөн тайлан.**

Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

1,1 Монгол улсын мянганы хөгжлийн зорилтот суурилсан **Үндэсний хөгжлийн цогц бодлогод** дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажил тус аймагт хэвийн явагдаж байна. Салбарын зорилтуудаас эрүүл мэндийн бодлого, соёл урлагийн хөгжлийн бодлого, ядуурал ажилгүйдлийг бууруулах бодлогын хэрэгжилт 77,5-89,4 %-тай бусдаас өндөр үзүүлэлттэй байна. Харин жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хөгжил хүн ам зүйн бодлого, гадаад бодлогын талаар дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийн гүйцэтгэл хангалтгүй буюу бага хувьтай үнэлэгдлээ.

Нийтдээ 138 зорилт арга хэмжээний хэрэгжилтийг тооцон салбарын бодлого бүрт хувь тооцон үнэлгээ өгөхөд тус аймагт цогц бодлогын хэрэгжилт 63,0 % биелэлттэй байна.

1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

| № | Хөтөлбөрийн агуулга, хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц | | | | | | | хугацаа болоогүй | Тасарсан | Биелэлтийн дүн |
|-----|---|------------------|-------------|-----------|-----------|-----------|-----------|----------|------------------|----------|----------------|
| | | Нийт заалтын тоо | Үүний дотор | | | | | | | | |
| | | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 10% | | | |
| 1.1 | Эрүүл мэндийн бодлого | 18 | 7 | 9 | 1 | 1 | | | | | 90,5% |
| 1.2 | БСШУхааны бодлого | 21 | 17 | | 1 | 1 | 2 | | | | 89,5% |
| 1.3 | Хөдөлмөр эрхлэлт | 4 | 3 | 1 | | | | | | | 97,5% |
| 1.4 | Нийгмийн хамгаалал | 10 | 4 | 1 | 2 | | | | 3 | | 90,0% |
| 1.5 | Хүн амын бодлого | 3 | 2 | 1 | | | | | | | 96,6% |
| 2.1 | Макро эдийн засаг ,санхүү | 8 | | | 3 | 1 | 3 | 1 | | | 45% |
| 2.2 | Үйлдвэржүүлэх бодлого | 4 | 1 | 1 | 2 | | | | | | 82,5 |
| 2.3 | Хаа, хүнсний аюулгүй байдал | 28 | 11 | 7 | 4 | 4 | 1 | 1 | | | 80,3% |
| 2.4 | Дэд бүтэц ,хот байгуулалт | 5 | | 3 | 2 | | | | | | 82,0% |
| 2.5 | Орон нутгийн хөгжлийн бодлого | 6 | 1 | 1 | 2 | | 1 | 1 | | | 61,6% |
| 3. | Байгаль орчны бодлого | 19 | 4 | 3 | 5 | 5 | 1 | 1 | | | 68,9% |
| 4.1 | Эрх зүйн бодлого | 2 | | 1 | 1 | | | | | | 80,0% |
| 4.2 | Гэмт хэрэгтэй тэмцэх | 1 | | | 1 | | | | | | 70,0% |
| 4.5 | Иргэний нийгэм, төрийн удирдлага | 14 | | 5 | 7 | | 2 | | | | 71,4% |
| 5.1 | Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого | 1 | | | | 1 | | | | | 50,0% |
| 5.2 | Батлан хамгаалах бодлого | 1 | | 1 | | | | | | | 90,0% |
| 5.3 | Гамшгаас сэргийлэх бодлого | 1 | | 1 | | | | | | | 90,0% |
| | Нийт | 146 | 50 | 35 | 31 | 13 | 10 | 4 | 3 | | 78,6% |

1.3 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

| № | Салбар | Хөтөлбөрийн тоо | Үүнээс | | | | | | | Нийт |
|---------------|---------------------|-----------------|--------|-----|-----|-----|------|-----|----|------|
| | | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 10% | 0% | |
| 1 | Байгаль орчин | 13 | | 5 | 3 | 5 | | | | 70 |
| 2 | Хүнс, хөдөө аж ахуй | 9 | | 2 | 3 | 4 | | | | 65.5 |
| 3 | Боловсрол, соёл | 9 | | 5 | 2 | 2 | | | | 76.6 |
| 4 | Нийгмийн халамж | 4 | | 2 | 2 | | | | | 80 |
| 5 | Эрүүл мэнд | 9 | | 5 | 2 | 2 | | | | 76.6 |
| 6 | Хууль зүй | 6 | | 3 | 2 | 1 | | | | 76.6 |
| Нийт % | | | | | | | 71.7 | | | |

2. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ

2.1. Монгол улсын эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Үндсэн чиглэлд тусгасан 12 бүлэг зорилтын 59 заалтыг хяналтанд авч гүйцэтгэлийг тооцож үзэхэд 100% хэрэгжсэн ажил 21, 90% хэрэгжсэн ажил 24, 70% хэрэгжсэн ажил 12,50 ба 30 % хэрэгжсэн ажил тус бүр 1 байна. Нийлбэр дүнгээрээ үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт 84,8 хувьтай сайн үнэлгээтэй хэрэгжсэн./Биелэлтийн тайланг ге 6-гаас үзнэ үү/

2.2 Хууль тогтоомж , Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэнд хийсэн

хяналт шинжилгээ үнэлгээ

Тус аймгийн ЗДТГ улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа Засгийн газрын 113 тогтоол, засгийн газрын хуралдааны тэмдэглэл 13 –ыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулжээ.

2010 оны жилийн эцсийн гүйцэтгэлийг хянаж үзэхэд малын тэжээл бэлтгэх ногоон тэжээл тариалах, иргэний хувь хишиг хүртээлтийн талаар авах арга хэмжээний тухай, малын сэг зэм


устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах, хаврын хэрэглээний махны нөөц бүрдүүлэх талаар гарсан тогтоолуудын хэрэгжилт сайн байна.

Харин “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай”үндэсний хөтөлбөр,”Монгол бий биелгээг хөгжүүлэх”,”Хөгжлийн нэгдмэл байдлыг хангах хөтөлбөр”,”Боловсрол” үндэсний хөдөлмөрийн хэрэгжилт хангалтгүй явагдаж байна.

Засгийн газрын шийдвэрийн талаар хяналт шинжилгээ хийх явцад ихэнх тогтоол шийдвэр нь хөрөнгө санхүүгийн асуудлыг төсөв,үндсэн чиглэлд тусгахыг холбогдох сайд, аймгийн удирдлагад үүрэг болгожээ. Тухайлбал Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс сэргийлэх хөтөлбөр, Хүний эрхийг хангах хөтөлбөр, Хэмжлийн нэгдмэл байдлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тодорхойлсон санхүүжилт байдаггүй учир орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Архангай аймагт Засгийн газрын 113 тогтоолын 157 заалтын 71 нь бүрэн хэрэгжиж, 86 нь хэрэгжих шатандаа байна. Шийдвэрийн гүйцэтгэл 83,3 хувьтай хэрэгжиж байна.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурьдсан 26 заалтын 21 нь биелж, 5 нь хэрэгжих шатандаа байна.



2.3.Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлт

“Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 146 заалтыг хяналтанд авч ажиллав. Эдгээр заалтын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 2010 оны эцсийн байдлаар 68.6 хувьтай буюу 3.43 онооны үнэлгээтэйгээр хэрэгжүүлж байна

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажилласан бөгөөд ямар нэг эрх зүйн зөрчил, гэмт үйлдэлд холбогдоогүй болно

Аймгийн Засаг даргын Тамгын Газрын байранд “Нэг цонхны үйлчилгээний төв” нээж нийгмийн даатгал, хөдөлмөр халамж, газрын харилцаа, иргэний бүртгэл, банк, нотариатын үйлчилгээг нэг дороос үзүүлж байна. Бүрэн бус мэдээгээр 2010 онд тус төвөөр 2902 иргэн үйлчлүүлэв

Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого боловсруулах зорилгоор “Архангайн хөгжил-Өнөө ирээдүй” сэдэвт форумыг зохион байгуулж, бүх сум, баг, байгууллага, иргэдээр хэлэлцүүлж санал авсан нь “шийдвэр гаргахад иргэдийн оролцуулсан үр дүнтэй ажил боллоо

Санхүү төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай аймгийн Засаг даргын 145 дугаар захирамж гаргаж, төсвийн удирдлагыг сайжруулж үргүй зардлыг багасгах, төслийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлага үүсгэхгүй байх зорилт тавьж ажилласнаар үр дүнд хүрч аудитын байгууллагаас стандарт бус, сөрөг дүгнэлт авсан байгууллага, сум гараагүй болно.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 2584.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2972.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөөг 15.0%-иар давуулан биелүүллээ.

Монгол Улсын Засгийн Газрын 113 тогтоолын 157 заалт, Засгийн Газрын хуралдааны 13 тэмдэглэлийн 26 заалт, нийт 126 тогтоол, шийдвэрийн 183 заалтыг хяналтанд авч биелэлтийг хангуулж ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилт 85.0 хувьтай байна.

Батламжаар хүлээсэн үүргийн биелэлт 98,3 хувьтай байна гэж үнэлэв.

2.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан 175 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 428 ажил, арга хэмжээ бүхий төлөвлөгөөг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан мөрдөж байна. Үйл ажиллагааны хөтөлбөрөөс үр дүнтэй бүтээлчээр хэрэгжиж буй ажлууд болон хэрэгжилт удаашралтай байгаа зорилтуудыг хяналт шинжилгээний явцад тогтоон гүйцэтгэлийн явцад хувь тавьж үнэлгээ өгсөн.Тоймловол:

Эрүүл мэнд, спортын талаар:

Аймгийн Эрүүл мэндийн салбар нь 88000 гаруй хүн амд эрүүл мэндийн анхдагч, хоёрдогч лавлагаат тусламжийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум дундын 2 эмнэлэг, 17 сумын эмнэлэг, 8 хувийн хэвшлийн эмнэлэгт 143 их эмч, 27 бусад дээд мэргэжилтэн, 484 дунд мэргэжилтэн, 392 туслах ажилтан нийт 1054 хүний бүрэлдэхүүнтэйгээр үзүүлж байна.

Аймгийн хэмжээнд 559 ор ажиллаж ор хоногийн ашиглалт 82.4 хувьтай, нэг өвчтөний эзлэх дундаж ор хоног 7.8, амбулаториор 293332 хүн үзэж үзлэгийн хувь 84.4 , урьдчилан сэргийлэх үзлэгээр 121786 хүн үзэж 41.5 хувь, дархлаажуулалтын хамралт 97.4 хувьтай байна.

Бүх сумдыг ЭХО аппаратаар, Батцэнгэл, Тариат, Эрдэнэмандал, Ихтамир, Хайрхан, Хангай сумдыг хүчилтөрөгч өтгөрүүлэгчээр, Өлзийт, Өгийнуур, Цахир сумдыг авто клаваар тус тус хангалаа.

Эрүүл мэндийн байгууллагуудыг чанарын баталгаатай эмээр ханган, иргэдэд үйлчлүүлэх ажлын хүрээнд эмийн тендерийг зохих журмын дагуу шалгаруулан ажилласнаар аймгийн төвийн 5 эмийн сан, 16 сумын “Эмийн эргэлтийн сан”-д 31.7 сая төгрөг, Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн 5 эмнэлэг, Эрдэнэмандал, Тариат сумдын “Сум дундын эмнэлэг”-т 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Нийт эмийн хангалт 85.0 хувь, зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 87.0 хувьтай байна.

2009-2010 онуудад аймгийн эрүүл мэндийн салбарт томоохон хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдлээ. Тухайлбал: 1.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 30 ортой халдвартын болон хүүхдийн, Хотонт, Хашаат сумдын эмнэлгийн барилгыг тус тус шинээр барьж, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, төрөх тасаг, Хайрхан, Эрдэнэмандал, Жаргалант, Ихтамир, Өлзийт сумдын эмнэлгийн их засвар, Цэнхэр сумын эмнэлгийн сантехникийн засвар, Өгийнуур, Эрдэнэмандал сумдын эхчүүдийн амрах байрыг 1 тэрбум төгрөгөөр засварлаж иргэдэд эмнэлгийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүллээ.

Аймгийн нэгдсэн эмнэлгийг түргэн тусламжийн автомашин 4, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон явуулын амбулаторийн 2 автомашинаар хангаж, Чулуут, Эрдэнэмандал, Хангай, Төвшрүүлэх, Булган, Ихтамир, Хашаат, Өлзийт, Өгийнуур, Цэнхэр, Өндөр-Улаан, Биеийн тамир голомтот тус бүр хийв.



Хавтгай модонд барьж гүйлтийн уулын цанын

Батцэнгэл, Эрүүл мэндийн газар, спортын газар, Байгалийн халдварт өвчинтэй тэмцэх төвд автомашины парк шинэчлэлтийг

цанын баазыг 4,8 сая төгрөгөөр 500 м-ийн зам, чарганы зам, гулгах замуудыг тавьсан байна.

Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хотын тохижилт, соёлжилтийг сайжруулах зорилгоор барилгачдын талбайд 70.0 сая төгрөгийн өртөг бүхий усан оргилуур байгуулжээ.

**Цаашид өрхийн эмнэлгийг бэхжүүлэх, эх хүүхдийн хоол тэжээлийн төв байгуулах, ахмад настны эмийн сан байгуулах, сумдын эмнэлэгт шүдний эмч ажиллуулах, зайны оношлогоог өргжүүлж эрт оношлох, , эрүүл мэндийн салбарын үндэсний хөтөлбөрүүдийн үр нөлөөг тооцож хэрэгжилтийг чанаржуулах, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтын гүйцэтгэлд анхаарч ажиллах шаардлагатай. Эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах, барилга байшин барих, засах, автомашиныг шинэчлэх зэрэг хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, хүний нөөцийн бэхжилт, үйл ажиллагааны зардал хэвийн хэмжээнд сайн байгаа эрүүл мэндийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт буурсан байна. Эрүүл мэндийн салбарын хамааралтай зорилтын хэрэгжилт 65,0% байна.*

Боловсрол, соёлын талаар

2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 676 бүлэгт 20164 хүүхэд суралцаж байна. Суурь боловсролын хамран сургалт 94.2 хувьтай байна.

Хөдөөгийн 56 багт гэр цэцэрлэг ажиллуулснаар цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 45.8 хувь буюу 2931 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтанд 29.2 хувь буюу 1756 хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 77.2 хувьд хүрлээ.

Боловсрол соёлын салбарт 2008 онд 653.2 сая төгрөг, 2009 онд, 2.7 тэрбум төгрөг, 2010 онд 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ. Тухайлбал: Өгийнуур сумын сургуулийн спорт заал, Өлзийт сумын сургуулийн дотуур байр, Тариат сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны өргөтгөл, Цахир сумын соёлын төв, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Батцэнгэл сумдад хүүхдийн цэцэрлэгийн барилгыг тус тус шинээр барьж ашиглалтанд орууллаа.



Өлзийт, Хашаат, Цэцэрлэг, Чулуут, Өгийнуур сумдын сургуулийн хичээлийн байр, Тариат сумын хүүхдийн цэцэрлэг, Цэнхэр, Хангай, Эрдэнэмандал сумдын сургуулийн дотуур байр, Эрдэнэбулган сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэг, Хотонт сумын Өндөр сантын багийн соёлын төв, газар хөдлөлтийг бүртгэх “Цэцэрлэг” станцын засварын ажил 1.1 тэрбум төгрөгөөр хийгдээд байна.

Аймгийн хэмжээнд бичиг үсэг үл мэдэгч 667 иргэний 334 иргэнийг бичиг үсгийн сургалтанд хамруулж, бичиг үсэг тайлагдалтын түвшин 98.7 хувьтай байна.

Чулуут сумын ахлах сургуульд “Үдийн цайны газар”-ыг барьж ашиглалтанд оруулан, Чулуут, Хайрхан сумдын сургуулийн үдийн цайны газрын тоног төхөөрөмжийг шинэчилж,

Эрдэнэмандал, Батцэнгэл, Булган сумын цэцэрлэгийг 40.8 сая төгрөгийн 13 төрлийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Хөгжимт драмын театрын уран бүтээлчдээс 2009 онд 2, 2010 онд 4 уран бүтээлчдийг аймгийн Засаг даргын болон байгууллага, хувь хүний тэтгэлгээр СУИС-д сургаж байна.

2010 онд хүүхдийн Тамир зусланд 504 хүүхдийг амраан хөгжил оролцоог нь ханган ажилласнаар зусланд амарсан хүүхдийн тоо нэмэгдсэн төдийгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд чанарын өөрчлөлт гарч, амрагч хүүхдийн орчин нөхцөл сайжирлаа.

-*Хүүхдийн цэцэрлэгүүдийн гадна талыг тохижуулж, тоглоомын талбай байгуулах, Цогчин дуганыг сэргээх, соёлын талаар баримтлах бодлого боловсруулж батлуулах зорилтын гүйцэтгэл хангалтгүй хэрэгжиж байна.

Цаашид Англи хэлний хөтөлбөрийг иргэд рүү чиглэсэн үр дүнтэй хэрэгжүүлэх, “Багш хөгжлийн төв” –ийг жинхэнэ утгаар нь бий болгох, хүүхэд залуучуудын паркийг тохижуулж хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай юм.

Нийгмийн хамгааллын талаар:

Аймгийн нийт хүн ам 89.3 мянга, үүнээс хөдөлмөрийн насны хүн ам 53.3 хувь, эдийн засгийн идэвхтэй хүн ам 41.5 хувь, ажиллагсад 40.2 хувь, бүртгэлтэй ажилгүйчүүд 1824, ажилгүйдлийн түвшин 4.34 хувьтай байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан бусад төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдийн бизнесийн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих, төрийн байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангах зэрэг арга

хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2835 ажлын байр шинээр бий болсон байна.



“Нийгмийн эмзэг бүлгийн зарим хэсэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 1742 иргэнд 230,8 сая төгрөгийн хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг олголоо.


2009-2010 оны байдлаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэн, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж 103.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснээр үйлчилгээнд 1756 иргэн хамрагдсан бөгөөд үүний 57.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 21.2 хувийг ахмад настан, 3.7 хувийг бүтэн өнчин хүүхэд, 10.4 хувийг ядуу иргэд, 7.8 хувийг нь өрх толгойлсон эцэг, эхчүүд эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалд 89331 иргэн хамрагдахаас 65501 хүн хамрагдаж төлөвлөгөө 73.3 хувьтай, нийгмийн даатгалд хамрагдвал зохих иргэдийн 22.8 хувь нь хамрагдаад байна.

Шивэрт дэх Ахмадын амралт сувиллын барилгыг засварлан ахмад настны амрах ая тухтай орчныг бүрдүүлснээр 715 ахмад амарч сувилуулсан байна. Мөн нийгмийн халамжийн сангаас Хасу Шивэрт амралтанд амарсан 450 ахмад настны зардалд 25.9 сая төгрөг, Буянт амралт сувилалд амарсан 635 иргэний зардалд 38.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

****Энэ салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байртай болгох, дэмжих, иргэдээ гадаадад ажиллахад нь туслах, эрүүл мэндийн даатгалд нийт иргэдийг хамруулах зорилтын хэрэгжилт сул байна. Гүйцэтгэлийн дундаж 74,6 хувийн биелэлттэй.***

Эдийн засаг, санхүүгийн талаар:



Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2009 онд 95512.5 сая төгрөгт хүрч өмнөх оныхоос 4.9 хувиар өссөн. Харин 2010 оны урьдчилсан байдлаар малын тоо хорогдож мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ буурснаас шалтгаалан 6.0 хувиар буурах хандлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009-2010 онд 5.5 тэрбум төгрөг батлагдан хэрэгжсэнээс одоогийн байдлаар

гүйцэтгэлээр 4.4 тэрбум төгрөгийн ажил санхүүжигдэн хэрэгжиж байгаа

Аймагт арилжааны банкны 5 салбар 39 нэгж үйл ажиллагаа явуулж нийт харилцагчдын тоо 86.0 мянгад хүрч, бүх салбар нэгжүүд онлайн системд холбогдон банкны үйлчилгээ түргэн шуурхай чирэгдэлгүй болсон

Аймгийн арилжааны банкны салбар, нэгжүүд иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулахад зориулан 38334 хүнд 31.1 тэрбум төгрөгийн зээл олгосноос үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 261 хүнд 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

****Татварын байцаагчдыг онлайн сүлжээнд холбох, аймаг сумын төрийн сангийн төлөөлөгч нарын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилтын хэрэгжилт удаашралтай байгааг анхаарч цаашид эдийн засгийн судалгааг шийдвэр гаргахдаа ашиглаж байх шаардлагатай.***

Үйлдвэр хөгжүүлэх талаар:

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас төсөл сонгон шалгаруулах замаар нийт 134 төсөлд 1.4 тэр бум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг с рын 1 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар олголоо. Үүний үр дүнд 2009-2010 онд аймгийн хэмжээнд шинээр 30-аад жижиг, дунд үйлдвэр, цех ашиглалтанд орж 200 гаруй ажлын байр шинээр бий боллоо.

Барилгын материалын хэрэгцээ шаардлагыг үндэслэж Эрдэнэбулган, Цэцэрлэг, Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумдад тоосго, блок, алаг чулуун хавтан, шохойны үйлдвэрлэл эрхлэх 11 иргэн, аж ахуйн нэгжид 123.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүллээ. Эрдэнэбулган сумын 5-р багт тоосгоны үйлдвэр, Халуун цогтой ХХК-ны шахмал түлшний үйлдвэр тус тус байгуулагдан ажиллаж байна.

Төвшрүүлэх сум дахь төмрийн үйлдвэр баяжмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ангижруулах үйлдвэр барьж байна. Тус үйлдвэрийг 2011 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.



Хайрхан, Булган, Өндөр-Улаан сумдад сүү боловсруулах, Эрдэнэбулган сумын “Од-Кр” хоршоонд хүнсний ногоо даршилж савлах тоног төхөөрөмж нийлүүлснээр эрүүл, цэвэр хүнсээр иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүрээ өсч байна.

Мөн төмс, хүнсний ногоо нөөшлөх, савлагаатай төмс, хүнсний ногоо, нарийн ногоо нийлүүлэх, чацаргана тариалах, хүлэмж, зоорийн аж ахуй эрхлэх төслийг дэмжиж Эрдэнэбулган, Төвшрүүлэх, Чулуут, Өлзийт, Тариат сумдын 24 иргэнд 241.2 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлээ.

Эрдэнэбулган, Хашаат, Батцэнгэл сумдад мах хадгалах, савлах, бэлтгэх, борц, бууз, банш хийх, хиам үйлдвэрлэх, махны хөргүүртэй зоорийн аж ахуй байгуулах 9 иргэн, аж ахуйн нэгжид 152,0 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд Эрдэнэбулган сумын 5-р багт 110 тн мах хадгалах зорь ашиглалтанд орлоо. Эгнэшгүй эх ХХК-ний борцны үйлдвэр бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна.

Цөм сүргийн үржлийн төвийг түшиглэн Эрдэнэбулган суманд фермерийн аж ахуй байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Фермерийн аж ахуй эрхлэх санаачилга гаргасан Эрдэнэбулган, Чулуут, Эрдэнэмандал, Хотонт сумын 12 төсөлд 142.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.

2010 онд аймгийн хэмжээнд 3515 га талбайд үр тариа тариалж, 2347 тн ургац хураан авсан нь аймгийн жилийн хэрэгцээт гурилын 30 хувийг хангах түвшинд хүрлээ.

Хасу холдинг ХХК-ний гурилын үйлдвэр үйл ажиллагаа явуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна. Гурилын үйлдвэр байгуулах чиглэлээр Төвшрүүлэх сумын Багахангай ХХК-д 24 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна.



Хайрхан суманд сүү боловсруулах цех болон Эрдэнэбулган сумын “Баян-Баян уул” хоршооны сүү, тараг савлах жижиг үйлдвэр ашиглалтанд орж үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ Хүнс Архангай ХХК нь Жижиг Дунд Үйлдвэрийг Дэмжих Сангийн 500.0 сая төгрөгийн зээлд хамрагдан хоногт 2000 литр сүү боловсруулах хүчин чадал бүхий сүүний үйлдвэрийг ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

Эрдэнэбулган суманд сав, баглаа боодол, цаасан уутны үйлдвэрлэл, дээврийн төмөр хэвлэх болон цэвэр усны үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжиж 6 иргэн, аж ахуйн нэгжид 76,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд Эрдэнэбулган суманд

“Гост трейд” ХХК-ийн Тамир цэвэр усны үйлдвэр ашиглалтанд орж аймгийн ард иргэд орон нутагтаа үйлдвэрлэсэн цэвэр усыг хэрэглэх боллоо.

***Бизнесийн инкубатор төв байгуулах, сарлагийн хөөвөр боловсруулах үйлдвэр байгуулах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж хамтран ажиллах, загвар фермерийн аж ахуй байгуулах ажлыг хэрэгжилтийг эрчимжүүлж, төсөл өгснөөр асуудал шийдэгдэж буй бус гүйцэтгэлийг хянаж тооцож байх шаардлагатай гэж үзэж байна.**
Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын талаар:

2010 онд Цэнхэр суманд хонь, Цахир суманд ямаа төслийг хэрэгжүүлж Цэнхэр суманд улсын төсвийн 21.0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 багийн 60 өрхөд үржлийн жишигт тэнцсэн эм хонь олгож, Цахир суманд Ховд аймгаас ноолуурын чиглэлийн 230 ямаа авч үржүүлж байгаагийн зэрэгцээ Эрдэнэмандал суманд Сүхбаатар аймгаас Үзэмчин хуц, Баяндэлгэр үүлдрийн ухна авчирч Эрдэнэмандал сумын Арбаян-мандал хоршоог түшиглэн 800 эм хонь 400 эм ямаагаар үржлийн суурь зохион байгуулан нутгийн малын чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулж байна.

2010 оныг ногоон тэжээл тариалалтыг дэмжиж ажилласны үр дүнд 210 тн үрийг сумдад хуваарилан олгосноор 1300 га талбайд ногоон тэжээл тариалж 3244.5 тн ургац хураан авч таримал тэжээлийн хэмжээг өмнөх оныхоос 10 дахин нэмэгдүүллээ.

Хөдөөгийн Ядуурлыг Бууруулах Хөтөлбөрийн 80 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах санг байгуулан аймгийн өвс тэжээлийн нөөцийн салбарыг шинээр байгуулан ажиллаж байна.

Мөн Хотонт сумын Цагаан сүмийн услалтын системд 30 га-д ногоон тэжээл тариалж, 400тн ургац, Сүүл толгойн услалтын системд 90 га-д үр тариа тарьж, 180 тн ургац, 10 га-д төмс тарьж, 200 тн ургац, 26 га-д малын тэжээлийн ургамал тарьж 230 тн ургац тус тус хураан авлаа.

Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төвшрүүлэх суманд тариалан эрхлэлтийг дэмжих Техник дундын үйлчилгээний төвийг орон нутгийн өмчит аж ахуйн хэлбэрээр байгуулан ажиллаж байна.



ХЯБХ, Тогтвортой амьжиргаа-II төслийн хүрээнд 19 суманд 2067 га бэлчээр хадлангийн талбай хашиж хамгаалах ажлыг зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгөөр Хашаат, Хотонт,

Өлзийт, Цэнхэр, Батцэнгэл сумдын 84.0 мян.га талбайд авиа химийн аргаар, Цахир, Хангай сумд 20.0 мян.га талбайд ердийн механик бэлчээрийн үлийн цагаан оготны устгал хийж бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авлаа.

Сум бүрт 5 сая төгрөгийн өртөг бүхий 30 хүртэлх тоннын багтаамжтай зоорийг шинээр барьж хөдөөгийн газар тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын зоорь савтай болгох арга хэмжээ авлаа.

Зуданд нэрвэгдэж малгүй болсон 18 сумын 1151 малчин өрхийг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжинд хамруулж нийт 345.3 сая төгрөг олголоо. Засгийн Газрын 2010 оны 197 дугаар тогтоолын дагуу 10 сумын 229 өрхийг 389.3 сая төгрөгийн санхүүжилтээр малжуулахаар шийдвэрлэж холбогдох сумдад малжуулах журам зээлийн гэрээг хүргүүлэн ажиллаж байна.



2010 онд 1.3 сая толгой малыг халдварт өвчнөөс сэргийлэх тарилганд 0.8 сая толгой малыг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх, угаалга, туулгалтанд хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээ авлаа. Мөн бруцеллөз өвчний халдварлалтыг судлах лабораторийн шинжилгээг 30.1 мян.толгой малд хийсний зэрэгцээ ям өвчний шинжилгээнд 11.8 мянган адуу, сүрьеэ өвчний шинжилгээнд 46.9 мян.толгой малыг тус тус хамруулсан байна.

Дэд бүтэц, барилга, хот байгуулалтын талаар:

Өгийнуур-Хөшөө цайдмын 10км, Хархорин-Цэцэрлэгийн хотын чиглэлийн 115.4 км хатуу хучилттай замын ажлын 85.4 км замыг барьж дууссан ба үлдсэн 30 км, Ихтамир-Хануйн гүүр, Хануйн гүүр- Халзанбүргэтэй-Солонготын чиглэлд 218.2 км замын ажил хийгдэж байгаагаас 53,2 км хатуу хучилттай замын ажлыг дуусгаж үлдэх 165 км хатуу хучилттай замыг 2011 онд ашиглалтанд оруулахаар гүйцэтгэгч компаниуд ажиллаж байна. Улс ън төсөв болон орон нутгийн автозамын сангийн хөрөнгөөр орон нутгийн зам даваануудын засварыг нийт 130.0 сая төгрөгөөр гүйцэтгэлээ.

Аймгийн төвийн гэр хорооллын болон 6 сумын 0.4кв-ийн агаарын шугамыг шинэчлэх болон СИП кабелиар солих ажилд улсын төсөвт 897.0 сая төгрөг батлагдан ажлыг эхлүүлээд байна. Аймгийн төвд хөрөнгийн боломжид тулгуурлан шинээр суурьшсан гэр хорооллын 40 гаруй айлыг цахилгаанаар хангах арга хэмжээг авлаа.

Аймгийн төвийн хэсгийн нийтийн эзэмшлийн гудамжийн зарим хэсгийг тогтмол гэрэлтүүлэгтэй болгож энэ онд дээрх ажилд 75,0 сая төгрөг зарцууллаа.

Аймгийн төвд 140 айлын амины орон сууцны хороолол барих нэгдсэн зураглал гаргаж газрыг олгон сууцны загвар зургуудыг гаргаж орон сууцны хороолол барих ажлыг зохион байгуулж байна. Төрийн албан хаагч, иргэдэд зориулсан 30 айлын орон сууцны барилга ашиглалтанд ороод байна.



2009-2010 онд Жаргалант, Эрдэнэмандал, Хангай сумд, аймгийн Засаг даргын Тамгын Газрын барилгуудыг өргөтгөх ба засварлахад 175.3 сая төгрөгний хөрөнгө хуваарилан засварын ажлыг хийлгэв. Мөн 130 сая төгрөгөөр Эрдэнэмандал сумын Тээл, Цэцэрлэг сумын Хужирт, Өндөр-Улаан сумын Бэлх, Өлзийт сумын Байшир багийн төвүүдийг шинээр барьж, Жаргалант сумын Зуслан, Хангай сумын Баян-Улаан, Булган сумын Тамир, Эрдэнэмандал сумын Өлзийт, Эрдэнэ-Уул, Хан-Өндөр, Хашаат сумын Номгон, Өндөр-Улаан сумын Донгой, Төвшрүүлэх сумын Баян-Өндөр, Өгийнуур сумын Өгий, Тариат сумын Тэрх зэрэг 15 багийн төвийг засаж тохижуулав.


2009-2010 онд Тогтвортой амьжиргаа-II төслийн хүрээнд Цэнхэр, Тариат, Хангай, Чулуут, Өндөр-Улаан, Ихтамир, Цахир, Өгийнуур сумдад 2-4, Хайрхан, Хотонт сумдад 3 хүний халуун усны шинэ барилгыг барьж ашиглалтанд оруулаад байна.

****Орон сууцны загвар хороолол барих, Тамирын гол, Суман голын модон гүүрийг төмөр бетон болгох, аялал жуулчлалын баазуудын оролцоотойгоор орчмын замын засвар арчлалт хий, алслагдсан багуудад найдвартай холбоотой болгох, “орон сууц хөгжүүлэх сан” байгуулах, халаалтын шинэ технолги нэвтрүүлэх, шилэн кабелийн сүлжээний санхүүжилтийн асуудлыг тодорхой болгох зэрэг зорилтуудын хэрэгжилт***

бага хувьтай дүгнэгдсэн.Үлдсэн хугацааг зөв тооцон бүрэн биелүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах талаар:

Ногоон байгууламж бий болгох зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр 234 га-д, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 80 га-д, байгалийн сэргээн ургалтанд туслах ажил 80 га-д нийт 394 га-д тус тус ойжуулалтын ажил хийж амьдралтын чанар сайн байна



Ойн хайгуул судалгааны төв, ойн газартай хамтран аймгийн нийт нутаг дэвсгэрт ойн хортны явуул судалгааг 151,0 мянган га талбайд хийсний үндсэн дээр 69,3 мянган га талбайд хортон устгалын ажлыг хийж гүйцэтгээд байна.

Байгаль хамгаалах чиглэлээр ой бүхий сумдад “Ойн нөхөрлөл” байгуулах ажлыг эхлүүлж үйл ажиллагаа явуулахад нь мэргэжил, арга зүйн зөвөлгөө өгч байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 57 ойн нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж

байна.

Ой бүхий сумдын 21 нөхөрлөлд ойн санг гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж Засгийн Газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цөлжилт явагдаж буй Өгийнуур, Хашаат, Хайрхан, Эрдэнэмандал, Цахир, Өндөр-Улаан, Булган, Ихтамир сумдад 10,3 мянган ширхэг улиасны тарьц, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 5000 ширхэг улиасны мөчир,100 ширхэг шар хуайсны суулгацыг тарих аргачлалын хамт хүргүүлж цөлжилттэй тэмцэх ажлыг зохион байгуулаад байна.



Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулж, аймгийн Засаг даргын дэргэд аялал жуулчлалын зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 12 булаг, иргэд, аж ахуй нэгж, байгууллага, байгаль хамгаалагч нарын оролцоотойгоор 99 булаг нийт 111 булаг /шанд/-ийн эхийг хашиж хамгаалаад байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний болон газар тариалангийн зориулалттай газрыг аймаг, орон нутгийн сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаж 137 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулж 1890.5 га мөн тариалангийн газрыг Засгийн Газрын 2003 оны 28 дугаар тогтоолын дагуу давуу эрхээр 48 иргэнд 2145 га газрыг тус тус эзэмшүүлээ.

Давхардсан тоогоор 32 суманд 137 удаагийн газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулж, орон нутгийн төсөвт 2009 онд 160.3 сая төгрөг, 2010 онд 60.0 сая.төгрөгийг дуудлага худалдаагаар тус тус төвлөрүүлээд байна.

****Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлж үр дүнд хүргэх, халаалтанд хэрэглэж байгаа модны хэмжээг эрс багасгах, шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хэрэглээнд хэвшүүлэх талаар арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.***

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах талаар:

Төрийн үйлчилгээний чанар, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлж, сахилга дэг журмыг бэхжүүлж, үр дүнд чиглэсэн хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэхэд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж ирэв.

Аймагт зохиогдох хурал, семинарын нэгдсэн хуваарь боловсруулан 2009, 2010 оны байдлаар төрийн байгууллагын албан хаагчдын дунд 37 удаагийн сургалт семинар, зөвлөлгөөнийг аймагт зохион байгуулж давхардсан тоогоор 2416 албан хаагч оролцсон байна.

Архангай аймгийн хөгжлийн бодлогод олон нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотууд дахь нутгийн зөвлөл, “Хангайнхан” клубтай хамтран “Архангайн хөгжил –Өнөө, ирээдүй” сэдэвт форум, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, цаашдын хөгжлийн чиг хандлагаа тодорхойлон гаргалаа.

Багийн ИНХ, Засаг даргын ажлыг уялдуулах, тэдэнд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцааг сайжруулах замаар багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нарын сургалт семинар зохион байгуулж, Засгийн Газрын болон аймаг, сум, багийн Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар арга зүйн хичээл зааж, багийн ажлын дэвтэр хэвлүүлэн өгч, зарим гарын авлагаар хангав.

Төрийн захиргааны албан тушаалын сул орон тооны талаар агентлаг, сумдын Засаг даргын Тамгын Газраас судалгаа авч хянан нөөцөөс нөхөх боломжгүй орон тооны захиалгыг нэгтгэн Төрийн албаны зөвлөлд 9 ажлын байрны захиалга нийтэд зарлуулан 135 иргэн шалгалтанд орж 60 хүн тэнцсэн байна.

Аймгийн нэгдсэн Веб сайтыг интернетэд байршуулан ашиглаж эхэлснээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, аймаг, орон нутгийн талаарх мэдээ, мэдээлэл олон нийтэд нээлттэй болж иргэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүртэх шинэ орчин нөхцөл бүрдлээ.



Аймгийн Засаг даргын Тамгын Газраас зохион байгуулж шийдвэрлэж буй асуудал, орон нутгийн ажил үйлсийн талаар Засгийн Газрын вэб сайтад байршуулснаар хууль, эрх зүйн бүхий л мэдээ мэдээллийг түргэн шуурхай, үнэн зөвөөр хүлээн авч иргэдэд хүргэдэг болов. Энэ оны эхний 11 сарын байдлаар 403 иргэн, 187 төрийн албан хаагчдад эрх зүйн лавлагаагаар үйлчлэв.

Хууль хяналтын байгууллагуудаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон төрлийн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсний үр дүнд мал хулгайлах гэмт хэрэг 10.3 хувь, онц хүнд гэмт хэргийн гаралт 42.8 хувь, захиргааны зөрчил 19.4 хувиар буурсан боловч 2010 онд 421 холбогдогч бүхий 482.4 сая төгрөгийн хохиролтой, 413 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32-оор буюу 8.4 хувиар өссөн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын Газарт 2010 оны эхний 11 сарын байдлаар 267 иргэн өргөдөл ирүүлснийг хүлээн авч хариу өгснөөс 41 иргэнд 1360.0 мянган төгрөгийн тусламж үзүүлж, төрийн албан хаагч 7 хүнд 3.1 сая төгрөгийг орон сууцны дэмжлэгт зориулан олголоо.

Мөн ОБЕГ-аас тус аймгийн Онцгой байдлын хэлтэст ГАЗ-66 автомашин, ариутгалын автомашин, тусгай зориулалтын хувцас хэрэгсэл зэрэг 45.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Аймгийн Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

| № | Зорилт, хэмжээ | арга | Нийт заалт тоо | Хэрэгжилтийн явц | | | | | | Хугацаа болоогүй | Хэрэгжилтийн дүн |
|---|----------------|------|----------------|------------------|-----|-----|-----|-----|-----|------------------|------------------|
| | | | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 10% | | |
| | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|--------------------|-----|-----|----|----|----|----|----|----|--------|
| 1 | Эрүүл мэнд | 69 | 13 | 13 | 12 | 15 | 10 | 5 | 2 | 65,0% |
| 2 | Боловсрол, соёл | 67 | 18 | 14 | 12 | 6 | 7 | 4 | 6 | 72,9 % |
| 3 | Нийгмийн хамгаалал | 31 | 6 | 9 | 8 | 3 | 4 | | 1 | 74,6% |
| 4 | Эдийн засаг | 26 | 8 | 10 | 4 | 2 | 2 | | | 82,3% |
| 5 | Үйлдвэр, дэд бүтэц | 85 | 28 | 20 | 18 | 15 | 5 | 3 | 2 | 73,7% |
| 6 | ХАА | 44 | 11 | 16 | 12 | 3 | 1 | 1 | | 81% |
| 7 | Байгаль орчин | 37 | 7 | 10 | 11 | 2 | 2 | 3 | 2 | 70,2% |
| 8 | Төрийн захиргаа | 69 | 32 | 13 | 15 | 6 | 3 | | | 78,7% |
| | нийт | 428 | 123 | 98 | 92 | 51 | 34 | 16 | 14 | 76,0% |

3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт

ТБУСТ хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч сайдуудтай аймгийн Засаг дарга асан Т.Цэдэндамбаа бүтээгдэхүүн нийлүүлэх санхүүжилтийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу үйл ажиллагааг чиглэл тус бүрийн агентлагуудад Ерөнхий менежерийн гэрээ байгуулан ажилласан байна. Гэрээний тал субъект болсон аймгийн Засаг дарга албан тушаалаасаа солигдсон ч төрийн албаны залгамж чанарын дагуу гэрээгээр хүлээсэн үүргээ талууд хэвийн хэрэгжүүлсэн байна.

3.2 Ерөнхий менежертэй байгуулсан гэрээний биелэлт

Аймгийн Засаг дарга нь ТБУСТХууль болон Төрийн албаны зөвлөлийн 87 дугаар тогтоолын дагуу тухайн төсвийн жилд хийж хэрэгжүүлэх ажлыг чиг үүргийн дагуу гүйцэтгүүлэхээр сумдын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх санхүүжилтийн гэрээ, эрхлэх хүрээний 23 агентлаг, байгууллагын дарга нартай Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна.

Агентлагын дарга нартай Төсвийн тухай хууль, 2010 оны нийгэм эдийн засгийн Үндсэн чиглэл, Засгийн газрын болон орон нутгийн түвшинд баримталж байгаа бодлого зорилт, хөтөлбөрүүдийг үндэслэн журмын дагуу гэрээ байгуулж хэрэгжилтийн явц, үр дүнг 2 удаа хяналт шинжилгээ хийж дүгнэлээ.

Ерөнхий менежерийн гэрээнд Засаг даргын албан даалгавар, захирамжаар өгсөн үүрэг даалгавар, авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах, төсвийн удирдлагын менежментийг зөв удирдаж бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилтуудыг тусгай захиалгат бүтээгдэхүүн болгон тусгасан.

Агентлагуудын ажил, Менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийн талаар тухайн байгууллага болон Тамгын газрын харъяа хэлтэс дээр хэлэлцэн, **дүнг Засаг даргын Зөвлөлд танилцуулан, үнэлгээг Засаг дарга өгсөн нь гэрээний хариуцлагыг өндөржүүлж, цаашид ахиц өөрчлөлт гарахад түлхэц болсон байна.**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Менежерүүдийн гэрээнд хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөхдөө бодит байдлыг газар дээр нь очиж үзэж танилцах, хэрэглэгчийн үнэлгээтэй харьцуулах, ярилцлага хийх зэрэг аргуудыг хослуулан хийсэн тул үнэлгээг бодитой дүгнэгдсэн. Нийтлэг дүнгээрээ Ерөнхий менежерүүдийн гэрээний дундаж 88,6 %, сумын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх санхүүжилтийн гэрээ 76,3% биелэлттэй дүгнэгдсэн.

4.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

| д/д | Шалгуур үзүүлэлт | заалт | Биелэлт /хувиар/ | | | Үнэлгээ |
|-----|--|-------|------------------|-----|-----|---------|
| | | | 100% | 90% | 70% | |
| 1 | Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал | 7 | | + | | 3.5 |
| 2 | Хүний нөөцийн бодлогын ил тод байдал | 6 | | + | | 3.0 |
| 3 | Төсөв, санхүүгийн ил тод байдал | 7 | | + | | 3.5 |
| 4 | Бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны ил тод байдал | 10 | 4 | 4 | 2 | 4.5 |
| | Үнэлгээний дундаж | | | | | 3.6 |

5.Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

1. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

Аймгийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн үнэлгээг статистикийн болон бусад холбогдох мэдээллийг судлан өмнөх оныхтой харьцуулан гаргав. Эдийн засгийн гол үзүүлэлт өмнөх оныхоос буурсан байна. Тухайлбал өнгөрсөн өвөл хаврын зуднаас мал их хорогдож, малчдын орлогын эх үүсвэр буурч амьжиргааны нөхцөл хүндэрсэн нь дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ багасхад нөлөөлжээ. Мөн өндөр ашиг шимт малын тоо толгой ч буурсан байна.



Мөн тус аймгийн эмч эмнэлгийн ажилтнуудын хариуцлага, ур чадварын байдлаас шалтгаалж эрүүл мэндийн гол үзүүлэлт эхийн эндэгдэл, нялхсын эндэгдэл, халдварт өвчний гаралт гаралт буураагүй нэмэгдсэн байна.

Бусад үндсэн үзүүлэлт харьцангуй сайн буюу өмнөх оныхоос сайжирсан. Ерөнхий дундаж үнэлгээ нь 4,5 оноотой дүгнэгдэв.

2. Хэрэглэгчийн үнэлгээ

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хөдөөгийн иргэд, аймгийн төвийн иргэд, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа гэсэн 3 хувилбараар тус тус авч үнэлгээ өгсөн.

Аймаг орон нутагт төр засгийн бодлого хэрхэн хэрэгжиж буй байдал, аймаг сумын засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц , төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар 19 асуулга бүхий санал асуулгыг 18 сумын 380 иргэнээс авсан. Хэрэглэгчийн үнэлгээний санал асуулгыг боловсруулахдаа иргэдэд ойлгомжтой хялбар байх үүднээс шууд үнэлгээ өгөх хувилбартай бас өөрийн санаа бодлоо үгээр бичих боломж олгосон юм.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг бүх сумдыг хамруулан зохион байгуулах явцдаа үзлэгийн бүрэлдэхүүнд оролцсон багийн гишүүд тухайн сумдын иргэдээс нууцлалыг ханган үнэлгээний хуудсаар иргэдийн сэтгэл иргэдээс гаргаж буй санал үнэлгээнд харгалзах үзүүлэлт болгон шүүмжлэлийг бүгдэд уншин байр суурийг сумдын удирдлага , авсанаараа чухал ач холбогдолтой



ханамжийн үнэлгээг авч, дүнг нэгтгэн дүгнэлтийг үзлэгийн нэгдсэн дүнгийн оруулж, иргэдийн бичсэн санал танилцуулж байсан нь олон түмний бодол үйлчилгээний байгууллагынхан ойлгож болсон.

Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас гарч байгаа тогтоол шийдвэр иргэдэд хэрхэн хүрч байгаа талаар Иргэний нийгмийн байгууллагуудаас 7 асуулга бүхий санал асуулгыг 124 иргэнээс авч дүгнэлт гаргасан. Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас гарч байгаа тогтоол шийдвэртэй дор бүр нь танилцах боломж олддог уу гэсэн асуулгад 17 хүн хүссэн үедээ танилцах боломжтой гэсэн бол 38 иргэн үзэж танилцах боломж олддоггүй, 62 иргэн ямар ч байсан хүн бүхэнд ил тод байдаггүй, 7 хүн нууцалдаг юм бишүү гэж хариулжээ. Мэдээллийн ил тод байдал хангагдаагүй, гарсан шийдвэрээ сурталчилдаггүй, иргэдэд амлалтаа биелүүлдэггүй, ажилгүйдэл бууруулах дорвитой арга хэмжээ авдаггүй, хог бохирдол ихтэй байгааг иргэд шүүмжилсэн байна.

Хэрэглэгчийн үнэлгээний нийлбэр дундаж нь сумдад 3,2, аймгийн төвд 3,3 буюу **дунд зэрэг** гэсэн үнэлгээг өгчээ.

Тамгын газрын дарга



Ч.Хүрэлчулуун

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
 (2010 оны үйл ажиллагааны үр дүн)

| □ | Үзүүлэлт | | Үр дүнгийн үнэлгээ | |
|------------------------|--|---|--------------------|------|
| | | | хувь | оноо |
| 1 | Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ | 1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт | 63,0 | 3,1 |
| | | 2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 78,6 | 3,9 |
| | | 3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт | 72 | 3,6 |
| Үнэлгээний дундаж оноо | | | | 3.5 |
| 2 | Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ | 1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт | 84.8 | 4.2 |
| | | 2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт | 95,0 | 4,7 |
| | | 3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт | 98.3 | 4.9 |
| | | 4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 76,0 | 3,8 |
| Үнэлгээний дундаж оноо | | | | 4.4 |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ | 1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт | 91.0 | 4.5 |
| | | 2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт | 88,6 | 4,4 |
| Үнэлгээний дундаж оноо | | | | 4.4 |
| 4 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ | 1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал | 90.0 | 4.5 |
| | | 2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал | 90.0 | 4.5 |
| | | 3.Төсөв, санхүүгийн ил тод байдал | 91.0 | 4.5 |
| | | 4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал | 83.0 | 4.1 |
| Үнэлгээний дундаж оноо | | | | 4.4 |
| 5 | Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ | 1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ | | 4,5 |
| | | 2.Хэрэглэгчийн үнэлгээ | | 3,2 |
| Үнэлгээний дундаж оноо | | | | 3.8 |

| | | |
|------------------------|--|------------|
| <i>Ерөнхий үнэлгээ</i> | | <i>4.1</i> |
|------------------------|--|------------|

Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасаг